



"ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ" ХХК
НИЙТЛЭН БОДОХ БҮРТГЭЛИЙН АУДИТ, БИШЭЭ ЖӨМӨНГӨ

Равибулаг төв 509 тоот, Жинэжэвчин гудамж 4/3,
Бодь цимхагийн баруун талд, Чингэлтэй дүүрэг 2-р хороо,
Улаанбаатар хот, Монгол улс.
Утас: 976 99061771, 976 99100779
И-сэйл: info@imkaudit.mn ТЭБ сафт: imkaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"МОНГОЛ ДААТГАЛ" ХХК –ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Бид **"МОНГОЛ ДААТГАЛ" ХХК**-ийн (цаашид "компани" гэх) 2014 оны 12 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Компанийн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах хорооноос баталсан, заавар журмын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, үүнтэй холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагууд орно.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол хийсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт, ёс зүйн шаардлагын дагуу гүйцэтгэв. Энэхүү стандартаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэдэг үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгуудыг талаар аудитын нотлох зүйл олж авах түүврийн горимыг гүйцэтгэх ажил багтана. Сонго авах горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж болох эрсдлийн үнэлгээг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь компани дотоод хяналтын үр нөлөөтэй байдлыг харгалзаж үздэг ба энэ талаар дүгнэлт гар зорилгоор биш, зөвхөн тухайн нөхцөлд зохистой аудитын горимуудыг тодорхойло чиглэдэг.

Аудит нь мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан б бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллу бодит байдал, санхүүгийн тайлангуудын ерөнхий толилуулгыг үнэлэх ажил багтаана.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)


Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр “МОНГОЛ ДААТГАЛ” ХХК-ийн 2014 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар бэлтгэгдсэн эдгээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан, заавар журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Бусад

Энэ дүгнэлтийг өөр аливаа нэг этгээдэд биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан, тэдний хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр хийсэн аудитдаа үндэслэн гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХӨТ, МОНГОЛ УЛС

2015 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 12